

2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

2021/06/10

Д/д	Байгууллагын нэр	Өгсөн зөвлөмж	Тоо	Дүн /сая.төг/	Биелэлт тооцох огноо	Хэрэгжилтийн байдал			Хэрэгжилтийн хувь		Зөвлөмж өгсөн		Тайлбар өгөх /Зөвлөмж хэрэгжүүлэх арга зам/
		Утга				Биелэлт тооцож ирүүлсэн огноо	Харилцагч байгууллагаас ирүүлсэн	ҮАГ-ын хяналтаар	Харилцагч байгууллагаас ирүүлсэн	ҮАГ-ын давтан хяналтаар	Байгууллага	Харуцсан аудитор	
1		Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан кассын зарлагын гүйлгээ хийх дээд хязгаарыг давсан 21 удаагийн 54.1 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ хийсэн.	1	54.1	2021/06/10		НББ-ийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулсан хувилбарыг бэлтгэсэн. Захирлын зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулна. Түүнчлэн урьдчилсан байдлаар Гүйцэтгэх захирлын 2021/05/07-ны өдрийн 1/665 тоот албан даалгавараар НББ-н бодлогын баримт бичгийн 2.2.4.1.1 мөрдөж ажиллахыг даалгасан.						НББ-н бодлогын баримт бичгийн 2.2.4.1.1 мөрдөж ажиллах
2		Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу дансны авлагад 3,069.0 сая, бэлтгэн нийлүүлэгчээс авах авлагад 21.2 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц үүсгэн бүртгэсэн нь нийт цахилгаан, эрчим хүчний авлагын 7.4 хувийг эзэлсэн, авлага барагдуулалтын хэлтсээс ирүүлсэн найдваргүй авлагын дүнгээс 2,596.6 сая төгрөгөөр илүү тооцсон. Мөн бараа материалын үлдэгдэлд 2,861.4 сая төгрөгийн хасагдуулга тооцсон нь нийт бараа материалын үлдэгдлийн 24.7 хувийг эзэлсэн, 5 жилээс дээш насжилттай бараа материалыг 100 хувь	1	0.0	2021/06/10		Дансны авлага болон бараа материалын нөөцийн хасагдуулгын хувь хэмжээг шинэчлэх эсэх талаар захирлын зөвлөлөөр хэлэлцүүлж, хэрвээ шаардлагатай бол гарсан үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар эцэслэн шийдвэрлүүлнэ. /Танилцуулга хавсаргах/						Дансны авлага, бараа материалын хасагдуулгын нөөц тооцох хувь хэмжээг бодит байдалтай уялдуулан шинэчлэн тогтоож, нэгдсэн бодлогоор мөрдөж ажиллах, авлага барагдуулах, бараа материалын эргэлтэд оруулж үр ашигтай зарцуулах арга хэмжээ авч ажиллах

3		<p>Санхүүгийн тайланд 48,677.8 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл тусгагдсан байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд тусгагдаагүй, үүнээс 39,299.0 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг excel бүртгэлээр хөтөлсөн боловч 9,378.8 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл нь бүртгэгдээгүй, аль хөрөнгөд хамаарах нь тодорхойгүй байна.</p>	1	9,378.8	2021/06/10		<p>Дахин үнэлгээний 48.6 тэбум төгрөгний үнэлгээг дахин үнэлсэн хөрөнгө бүрд оноож тавих ажил хийгдэж эхэлсэн. Энэ нь 2009 оноос хойшхи үнэлгээний нэмэгдлийн нийт дүнг задаргаа байдлаар хөрөнгө нэг бүрт харгалзуулан харагдах байдлаар "Хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл"-ийн хүснэгтэнд загварчлан оруулах ажлын файл бэлтгэх ажил 95 хувьтай байна. Энэхүү файл бэлтгэх ажил дуусмагц "Интерактив Би Ай" ХХК-аар хүснэгтийн загварыг өөрчлүүлэх ажил хийгдэнэ. Үүнийг 2 дугаар улирлын балансаас өмнө дуусгах төлөвлөгөөтэй байна. Учир нь энэхүү ажлыг хийхийн тулд 1-5 сарын үндсэн хөрөнгийн бүх гүйлгээ устгагдсан. /Гарсан үр дүнгээр шинэчилсэн загвараар бэлтгэсэн тайланг хавсаргана/</p>						<p>Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд хөрөнгө нэг бүрт хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг тусган оруулж, данснаас хасагдсан хөрөнгөд хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандартын 41-д заасны дагуу хасалт хийж, үлдэгдлийг үнэн зөв тайлагнах</p>
4	УБЦТС ТӨХК	<p>Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2006 оноос хойш олгосон 289.0 сая төгрөгийн өртөгтэй 8 орон сууцыг үндсэн хөрөнгөөр бүртгэн холбогдох элэгдлийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Гэтэл 2 ажилтан орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээг өөрийн нэр дээр гаргуулан авсан, зарим ажилтан төлбөрийн тодорхой хэсгийг хувиараа төлсөн, 2013 оноос хойш хөрөнгийн өмчлөлийг шилжүүлэхээр хүсэлт гаргасан боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй.</p>	1	289.0	2021/06/10		<p>ТӨБЗГ-аас өмч хувьчлалаар бус бүртгэлээр буюу ажиллагсдын нийгмийн зардалд тусгах замаар асуудлыг шийдвэрлэж болох арга зүйн зөвлөгөө өгсөн тул Захирлын зөвлөлийн хурлаар тус орон сууцнуудыг зардалд суулгах талаар танилцуулахаар хүлээгдэж байна. Байрны гэрчилгээ нь нэр дээр гарсан гэх Б.Агваандугар, А.Адилбиш нар нь тухай үед "Орон сууц захиалан бариулах гэрээ"-ний үүргээ биелүүлсэн тул Компанийн төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-өөр хэлэлцүүлэн шийдвэрлэж Төрийн өмчин бодлого зохицуулалтын газарт хандан танилцуулахад байрны гэрчилгээг компанийн нэр дээр гаргуулах эсвэл тухайн худалдан авч байгаа ажилтны нэр дээр гаргуулсан байх гэдэг нөхцөл шаардлага тавигдаж байсан тул тухайн ажилтнууд холбогдох материалуудыг бүрдүүлж өөрсдийн нэр дээр байрны гэрчилгээг гаргуулан авсан байна. Харин одоо орон сууцаа хувьчлан авах хүсэлт гаргасан бусад ажилтнуудын хүсэлтийг Компанийн ТУЗ-д танилцуулан шийдвэрлүүлж 2006 оноос хойш олгосон 289.0 сая төгрөгийн өртөгтэй 8 орон сууцыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн асуудлыг Нягтлан бодох бүртгэлийн шаардлагад нийцүүлэн шийдвэрлүүлэхээр Захирлын зөвлөлд танилцуулах бэлтгэл ажлыг хийсэн.</p>				<p>УАГ, Мишээл - Од Аудит ХХК</p>	<p>Г.Түвшинзая, Э.Энхцэг</p>	<p>Ажилтнуудын эзэмшиж буй 289.0 сая төгрөгийн өртөгтэй 8 орон сууцыг холбогдох дээд байгууллагад хүсэлт гаргаж, шийдвэрлүүлэх, компанид ашиглагдахгүй хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэхгүй байх.</p>

5	<p>Санхүүгийн программаас цалингийн тооцооны хүснэгтийг бэлтгэн гаргахдаа зарим нэмэгдэл, суутгалын баганууд нь хүснэгтэд тусгагдаагүйгээс 151.7 сая төгрөгийн нэмэгдэл, 395.3 сая төгрөгийн суутгалын дүн нь цалингийн хүснэгтэд тусгагдаагүй буюу аль ажилтанд ямар төрлийн нэмэгдэл болон суутгал хийгдсэн нь тодорхойгүй мөн баталгаажсан цалингийн нэгтгэлийн хүснэгт нь цалингийн тооцооллын хүснэгтээс зөрүүтэй зэргээр аудитын явцад их хэмжээний цаг хугацаа хөдөлмөр зарцуулж, тулгалт хийхэд хүндрэлтэй, цалингийн хүснэгтийг буруу бэлтгэн гаргасан.</p> <p>Мөн тус компанийн төвийн хэсгийн ажилтнуудын хавсран ажилласны нэмэгдлийг түүвэрлэн шалгахад орон тоонд тусгагдаагүй албан тушаалыг хавсран ажилласнаар сар бүр тогтмол 17-оос 21 ажилтанд нийт 34.7 сая төгрөгийн хавсран ажилласны нэмэгдэл олгосон.</p>	1	34.7	2021/06/10		<p>Интерактив БИ Й ХХК-ийн холбогдох мэргэжилтэнгүүдтэй хамтран Цалингийн програмын тайлангийн загварыг өөрчилж анхан шатны баримтыг холбогдох тооцооллын дүнгээр баримтжуулж байна. /Өөрчилсөн цалингийн хүснэгтийн баримт хавсаргах/ Батлагдсан орон тоогоор 1920 ажилтантай. Үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан ажлын байрны тодорхойлолтод заагдаагүй ажил үүргийг гүйцэтгэх, үндсэн ажлынх нь зэрэгцээ мэргэжил, албан тушаалыг хавсруулан ажиллуулах зайлшгүй шаардлага гардаг. Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйл, Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйл, Захиргаа-Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 3.12-д заасны дагуу хавсран ажилласны хувийг олгосон бөгөөд хавсран ажиллуулахаар гаргасан 29 тушаалаас 27 тушаал цуцлагдсан. 2 тушаал хүчинтэй байна. Үүнд: ТХХХ-т жолоочийн орон тоо байхгүй үзлэг хийхэд зайлшгүй шаардлагаар цахилгаан хэмжүүрийн монтерт жолоочийн ажил үүргийг хавсруулан хувийн машинаар нь ажилд гаргадаг.</p> <p>2. ХАБЭА-н зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлуулах тухай Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалаар 50-100 ажилтантай нэгжид ХАБЭАХБ инженер ажиллана гэсэн байдаг. Зуслан ХҮТ-нь 31 ажилтантай орон тооны ХАБЭАХБИ ажиллуулах боломжгүй тул ТТҮХ-ийн ахлагчид ХАБЭАХБИ-ийн ажил үүргийг хавсруулан ажиллуулж байна. Дээрхи хавсран ажиллуулж байгаа 2 албан тушаалыг хослон ажиллуулах болгон өөрчилж байна.</p>				<p>Цалингийн тооцооллын хүснэгтийг санхүүгийн програмаас үнэн зөв бэлтгэн гаргах, сар бүрийн нэгтгэл цалингийн хүснэгтийг захирлаар баталгаажуулснаас хойш ажилтнуудын цалингийн дүнд өөрчлөлт оруулахгүй байх, Орон тоонд тусгагдаагүй албан тушаалд хавсран ажилласны нэмэгдэл олгохгүй байх</p>
---	--	---	------	------------	--	---	--	--	--	--

6	Дотоод аудитын албанаас тайлант хугацаанд салбар нэгжүүдэд аудит хийсэн боловч төв компанийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгээгүй, Эрчим хүчний яамны Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газраас илрүүлсэн алдаа зөрчлүүд болон тус аудитаар илэрсэн алдаа, зөрчлүүдээс үзэхэд дотоод аудитын хяналт үр нөлөөгүй байна.	1	0.0	2021/06/10	ЭХЯамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 6/1366 тоотын хариуг Гүйцэтгэх захирлын гарын үсэгтэй 2021.05.07-ны өдрийн 1/666 тоотор 45 хуудас бүхий хавсралтын хамт явуулсан болно. Дотоод аудитын албанаас 2020 онд хийгдсэн ажлын товч тайлан: -Төлөвлөгөөт шалгалт 56 -Гэнэтийн шалгалт 177 -Албан даалгавар,албан даалгаврын биелэлт 10 - Илүү цагийн бүртгэлийн шалгалт – 11 удаа - Сарын үр дүнгийн шалгалт цалин олгох тухай тушаалын биелэлт – 10 Дотоод аудитын албаны 2020 оны үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу болон нийт 17 нэгжийг хамруулан төлөвлөгөөт шалгалтыг 56 удаа хийсэн ба 154 үл нийцэл илрүүлж, цаашид анхаарч ажиллах талаар 267 зөвлөмж өгч ажилласан. Гүйцэтгэх захирлын баталсан 2020 оны төлөвлөгөөт шалгалтын графикт Санхүү бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд 3 дугаар сард шалгалт хийхээр төлөвлөсөн боловч Гүйцэтгэх захирлын болон албаны даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу нийт 177 гэнэтийн шалгалт хийгдсэнтэй холбоотойгоор СБХ-ийн шалгалт хийгдээгүй болно. 2021 оны батлагдсан шалгалтын графикийн дагуу 6 дугаар сард СБХ-ийн үйл ажиллагаанд шалгалт хийхээр төлөвлөж байна.					Дотоод аудитын алба нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь холбогдох хууль, дүрэм журам стандартад нийцсэн эсэхийг нягтлан шалгах, хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийж, зөвлөмж гаргах, биелэлтийг дүгнэх, эрсдлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилгыг биелееж ажиллах, хяналтын үр нөлөөтэй хэрэгжүүлэх
7	Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь тендерийн нээлтийн тэмдэглэл, үнийн саналын маягтад огт гарын үсэг зурж баталгаажуулаагүй, 208.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл нь дарга, гишүүдийн гарын үсгээр бүрэн баталгаажуулаагүй байна	1	208.9	2021/06/10	Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь тендерийн баримт бичигт дутуу байсан бүх гарын үсгийг гүйцээн зуруулж дууссан болно. Жич: Шалгалт орох үед ихэнх тендерийн баримт бичиг нь эцэслэж дүгнэгдэж дуусаагүй задгай байсан болно. Архивд хүлээлгэн өгөх дотоод журамд заасан хугацаа нь болоогүй байсан болно.				Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн нээлтийн тэмдэглэл, үнийн саналын маягт, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг дарга, гишүүдийн гарын үсгээр бүрэн баталгаажуулах	
Дүн		7.0	9,965.50							
НИЙТ ДҮН		7.0	9,965.50							

Зөвлөмжийн биелэлт гаргасан :

Д.Төгсжаргалан